ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ

Байршил:
Монгол Улс

Төслийн дугаар:
53423

Бизнесийн салбар:
Хот суурин газар ба байгаль орчны дэд бүтэц

Мэдээллийн төрөл:
Төрийн

Байгаль орчны нөлөөллийн ангилал:
Б

Батлагдах огноо:
2024 оны 4-р сарын 24

Төлөв:
Эцсийн хурлаар орсон, ТУЗ-ийн шийдвэр хүлээгдэж буй

Төслийн Хураангуйг нийтэлсэн огноо:
2023 оны 8-р сарын 22

Төслийн танилцуулга

250 орчим ор бүхий хүчин чадалтай шинэ нэгдсэн эмнэлгийн барилга байгууламжийн зураг төсөл, бүтээн байгуулалтад шаардагдах 43.2 сая ам.доллар хүртэлх хэмжээний зээлийг Монгол улсын Засгийн газарт олгох төсөл. Уг төслийг Монгол Улсын Эрүүл мэндийн яам болон Дархан-Уул аймагтай хамтран Дархан хотод хэрэгжүүлнэ.

Төслийн зорилго

Энэхүү төсөл нь Дархан хот болон Дархан-Уул аймгийн иргэдийг орчин үеийн, чанартай хоёрдогч шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээгээр хангахад чиглэнэ. Түүнчлэн уг төслийн хүрээнд баригдаж буй эмнэлгийн шинэ барилга байгууламжуудын нөөцийн үр ашгийн өндөр стандартыг хэрэгжүүлэх замаар дэд бүтцийн байгаль орчны тогтвортой байдлыг сайжруулна.

Шилжилтийн нөлөөлөл

Хүлээгдэж буй шилжилтийн нөлөөлөл (ХШН)-ийн оноо: 67

Төсөл нь эмнэлгийн шинэ барилгуудын нөөцийн үр ашгийг нэмэгдүүлэх замаар шилжилтийн Ногоон чанарт голлон төвлөрнө. Түүнчлэн Төсөл нь эрүүл мэндийн

чанартай тусламж үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх замаар Тэгш Оролцооны чанарыг дэмжинэ.

Харилцагчийн мэдээлэл

Монгол Улс

ЕСБХБ-ны санхүүжилтийн дүн

43,200,000.00 ам.доллар

Монгол Улсын Засгийн газарт олгох 43.2 сая ам.доллар хүртэлх хэмжээний зээлийг ЕСБХБ-ны Хувь нийлүүлэгчдийн тусгай сан (“ХНТС”)-гаас эсвэл олон улсын хандивлагч эсвэл хандивлагчдын 5 сая евро хүртэлх буцалтгүй тусламжаар хамтран санхүүжүүлнэ.

Төслийн нийт өртөг

48,600,000.00 ам.доллар

Нэмэлт ашиг тус

- Санхүүжилтийн бүтэц: бусад арилжааны санхүүжилтийн сонголтгүй бүс нутгийн улсын эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийн эрэлт хэрэгцээг нөхөх.
- Эрсдэл бууруулах: CO2 хийн ялгарлыг бууруулж, уур амьсгалын биет эрсдэлд тэсвэртэй байдлыг бий болгосноор хүлэмжийн хийн шилжилтийн эрсдлийг бууруулах.
- Стандарт тогтоох, төсөл ба харилцагчдад тогтсон стандартыг сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх: олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн барилгын ногоон схемтэй нийцүүлэх; худалдан авалтын олон улсын шилдэг стандартыг хэрэгжүүлэх.

Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны хураангуй

Б зэрэглэл (2019 БОНБ). Дунд-өндөр эрсдэлтэй. Байгаль орчин, нийгмийн гол эрсдэл болон нөлөөлөл нь барилга байгууламж байхгүй сул талбай дээр 250 ортой эмнэлэг барьж байгуулах, үйл ажиллагаа явуулахтай холбоотойгоор талуудын оролцоо, холбогдох зөвшөөрөл, хөдөлмөрийн нөхцөл, ХАБЭА болон байгаль орчны менежмент, барилгын талбайн хөдөлгөөний менежмент, гүйцэтгэгч компаниудын менежмент, барилгын аюулгүй байдал, тэр дундаа амь нас, галын аюулгүй байдал, үйл ажиллагааны үеийн халдварын хяналт, нянгийн эсрэг эсэргүүцэл (AMR), өвчтөний аюулгүй байдал болон гомдол гаргах механизм зэрэг болно.

Байгаль орчин, нийгмийн судалгааг хараат бус зөвлөх хийж дууссан ба энэ хүрээнд, төслийн газрыг очиж үзэх, техникийн болон байгаль орчин, нийгмийн

бичиг баримтуудтай танилцах, эмнэлгийн үйл ажиллагааг хариуцан явуулахаар санал болгосон байгаль орчин, нийгмийн байгууллагыг үнэлэх зэргийг гүйцэтгэлээ.

Эмнэлгийн концепцийн зураг төслийг гаргахдаа Улаанбаатар хотод шинээр баригдсан хоёрдогч шатлалын загвар эмнэлгийн техникийн үзүүлэлтүүдэд үндэслэн оношилгооны өндөр технологи, буюу хөнөөл хамгийн бага эмчилгээний аргыг ашиглах, өвчтөнд ээлтэй эмнэлгийн орчинг бий болгох, өвчтөний аюулгүй байдалд анхаарах, олон улсын жишигт нийцсэн байдлаар хийж гүйцэтгэсэн. Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөний (БОНҮАТ) дагуу Харилцагч Банкны гүйцэтгэлийн шаардлагуудыг (ГШ) биелүүлэхийг шаардана. Үүнд ISO стандартад нийцсэн Байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоог (БОНУБТ) бий болгох заалтууд багтана. Монгол Улсын хуулийн дагуу Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг 2024 оны 1-р хагаст багтаан хийж гүйцэтгэх бөгөөд үүний дараа Төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх зөвшөөрлийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас авах шаардлагатай болно.

Төсөл нь биологийн олон янз байдал, соёлын өвийн дурсгалт газруудад материаллаг нөлөө үзүүлэхгүй. Төсөл “EDGE” ногоон барилгын батламжид нийцэхийг зорино. Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөөг (ОТОТ) бэлтгэж, Харилцагчийн цахим хуудсанд байршуулна.

Үндсэн болон нөөц эрчим хүчний шугам, дулаан хангамжийн шугам, усан хангамжийн шугам, бохир усны шугам, харилцаа холбооны кабель, Төслийн талбайд хүрэх хоёр урсгалт зам, Төслийн талбайн ойролцоох үерийн хамгаалалтын шугам сүлжээ зэрэг холбоотой хэд хэдэн шинэ буюу шинэчлэх, сэргээн засварлах шаардлагатай ажлууд хүлээгдэж буй. Эдгээр хийгдэх ажлуудтай холбоотой мэдэгдэхүйц сөрөг нөлөөлөл одоогоор тогтоогдоогүй бөгөөд болзошгүй нөлөөллийг бага гэж үнэлсэн. Дархан-Уул аймаг эдгээр холбогдох барилга байгууламжийг хариуцах бөгөөд энэ талаар Дархан Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн яамтай байгуулах менежментийн гэрээнд тусгаж, байгал орчин, нийгмийн холбогдох хариуцлагуудыг хүлээнэ.

ЕСБХБ байгаль орчин, нийгмийн тайланг жил бүр хянаж, шаардлагатай бол газар дээр нь очиж танилцах замаар Төсөлд хяналт тавина.

Техник хамтын ажиллагаа ба буцалтгүй тусламжийн санхүүжилт

Төсөлд гарын үсэг зурахаас өмнө:
ТХА 1: ЕСБХБ-ны Тогтвортой дэд бүтцийн сан ("ТДБС”)-гийн санхүүжилтээр Төслийн ТЭЗҮ хийгдсэн.
ТХА 2: Японы засгийн газрын дэмжлэгтэй Япон-ЕСБХБ-ны Хамтарсан Сангийн санхүүжилтээр Төслийн хэрэгжилтийг дэмжих (ТХД) зөвлөхүүдийг сонгон шалгаруулахад туслах Түр хугацааны худалдан авалтын дэмжлэг

Төсөлд гарын үсэг зурсны дараа:

ТХА 3: Японы засгийн газрын дэмжлэгтэй Япон-ЕСБХБ-ны Хамтарсан Сангийн санхүүжилтээр Төслийн хэрэгжилтийг дэмжих (ТХД) зөвлөх
ТХА 4: ЕСБХБ-ны ТДБС эсвэл ХНТС-гаас санхүүжилт авахаар санал болгох Барилгын ажлын хяналтын Зөвлөх

Харилцагчийн холбоо барих мэдээлэл

Б.Сансармаа
sansarmaa@moh.gov.mn
976-99885540
www.moh.gov.mn
Монгол Улс, Улаанбаатар хот, Олимпийн гудамж 2, Засгийн газрын 8-р байр

Төслийн хураангуйг сүүлд шинэчилсэн огноо

2023 оны 8 дугаар сарын 22

Шилжилтийг ойлгох нь

Шилжилтийн нөлөөллийг хэмжих чиглэлд ЕСБХБ-ны баримталдаг арга хандлагын талаарх нэмэлт мэдээллийг эндээс авна уу.

Бизнесийн боломжууд

Бизнесийн боломжууд болон худалдан авалтын талаар харилцагч компанитай холбогдоно уу.

ЕСБХБ-тай хамтран ажиллах боломжууд (худалдан авах ажиллагаатай холбоогүй)-ын талаар сонирхвол дараах утасны дугаар, цахим хаягаар холбоо барина уу.

Утас: +44 20 7338 7168
Цахим шуудан: projectenquiries@ebrd.com

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээлэл авахыг хүсвэл ЕСБХБ-ны Худалдан авах ажиллагаа хэсэгт зочилно уу.

Утас: +44 20 7338 6794
Цахим шуудан: procurement@ebrd.com

Ерөнхий лавлагаа

Дэлгэрэнгүй лавлагааг ЕСБХБ-ны Лавлагааны маягт ашиглан авах боломжтой.

Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ)

БОНБ болон холбогдох Гүйцэтгэлийн Шаардлагууд (ГШ) нь ЕСБХБ-ны “байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил”-ийг хөхиүлэн дэмжих үүрэг амлалтаа биелүүлэхэд баримтлах арга замуудыг тодорхойлдог. БОНБ болон ГШ-д харилцагчийн зүгээс олон нийтийн мэдээлэл, хэлэлцүүлгийн талаарх үндэсний хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг дагаж мөрдөх , мөн оролцогч талуудын санал гомдол, ялангуяа харилцагч ба төслийн байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн талаарх санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг гомдол барагдуулах механизм бий болгох тухай тодорхой заалтууд багтсан байдаг. ЕСБХБ нь аливаа төслийн байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөллийн мөн чанар, цар хүрээнд дүйцүүлэн харилцагчдадаа, тухайн төслийн улмаас үүсэх эрсдэл, үр нөлөөллийн тухай мэдээллийг шаардлагын дагуу ил болгох, эсвэл оролцогч талуудтай утга учиртай зөвлөлдөх, тэдний санал хүсэлтийг харгалзан үзэж, хариу өгөх нэмэлт шаардлагыг тавьдаг.

Энэ чиглэлд ЕСБХБ-ны хэрэгжүүлдэг практикийн талаарх нэмэлт мэдээллийг БОНБ-д оруулсан болно.

Шударга ёс ба Хянан нийцүүлэлт

ЕСБХБ-ны Хянан нийцүүлэлт хариуцсан Захирлын Ажлын алба (ХНЗАА) нь сайн засаглалыг хөхиүлэн дэмжиж, олон улсын шилдэг арга туршлагад нийцүүлэн Банкны бүхий л үйл ажиллагаанд шударга ёсыг хамгийн дээд түвшинд хангахад анхаардаг. Төслүүд нь Банкинд шударга ёс, нэр хүндийн хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй эрсдэл үүсгэхгүй байх нөхцлийг хангахын тулд Банк бүх харилцагчдадаа шударга ёсны магадлах шалгалт хийдэг. Банк аливаа асуудлыг төслийн үнэлгээг батлах үе шатанд илрүүлэн тогтоож, шийдвэрлэх нь Банкны ажил гүйлгээний шударга ёсыг хангах хамгийн үр дүнтэй арга зам гэж үзэж байна. ХНЗАА нь эдгээр хамгаалалтын арга хэмжээг авахад голлох үүрэг гүйцэтгэж, мөн төслүүдийн хөрөнгө оруулалтын дараах шударга ёсны эрсдэлийг хянах, үнэлэхэд тус болдог.

Түүнчлэн, ХНЗАА нь ЕСБХБ-ны санхүүжүүлсэн төслүүдтэй холбоотой залилан мэхлэлт, авилга, хээл хахууль болон хууль бус үйлдлийн талаарх мэдэгдлийн мөрөөр хянан шалгах үүрэгтэй. Банкны ажилтнууд дотроос, эсвэл гаднаас залилан мэхлэлт болон авилгал үйлдэгдсэн хэмээн сэжиглэж буй хэн ч энэ тухайгаа Хянан нийцүүлэлт хариуцсан захиралд compliance@ebrd.com цахим шуудангийн хаяг руу бичгээр илтгэх ёстой. Мэдээлэгдсэн бүхий л асуудлын мөрөөр хянан шийдвэрлэх ажлыг ХНЗАА гүйцэтгэнэ. Нэр хаягтай болон нэр хаяггүй бүх мэдээллийг шалгана. Мэдээллийг Банкны албан ёсны хэл болон үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын хэлний алинаар ч үйлдэж болно. Ирүүлсэн мэдээлэл нь үнэн зөв байх ёстой.

Мэдээллийн хүртээмжийн бодлого (МХБ)

МХБ нь 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш ЕСБХБ мэдээллийг хэрхэн олон нийтэд ил тод болгох, өөрийн стратеги, бодлого болон үйл ажиллагааны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэн сурталчлах чиглэлд оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөх арга замуудыг тодорхойлсон байдаг. ЕСБХБ-ны цахим хуудаснаас ямар мэдээлэл авах боломжтойг мэдье гэвэл Мэдээллийн хүртээмжийн бодлого хуудсанд зочилно уу.

Мэдээлэл авах тодорхой хүсэлтээ ЕСБХБ-ны Лавлагааны маягт ашиглан илгээх боломжтой.

Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)

Хэрэв байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбоотой санал гомдлоо Харилцагч болон Банкинд тавьж шийдвэрлүүлэх (жишээлбэл: Харилцагчийн Төслийн түвшний гомдол барагдуулах механизмаар дамжуулж, эсвэл Банкны удирдлагатай шууд харилцах замаар) оролдлого, хүчин чармайлт нь амжилтгүй болвол, хувь хүн болон байгууллагууд санал гомдлоо ЕСБХБ-ны Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)-аар дамжуулан шийдвэрлүүлэхийг зорьж болно.

ТХХБМ нь Төсөлтэй холбоотой бусдад хор хохирол учруулсан (эсвэл учруулж болзошгүй) гэж үзэж буй асуудлуудыг хараат бусаар хянан шалгадаг. Энэхүү Механизмын зорилго нь байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбогдох асуудлуудыг шийдвэрлэх талаар Төслийн оролцогч талуудын хоорондох яриа хэлэлцээг дэмжих; Банк өөрийн Байгаль орчин, нийгмийн бодлого, эсвэл Мэдээллийн хүртээмжийн бодлого–ын Төсөлд холбогдох заалтуудыг дагаж мөрдсөн эсэхийг олж тогтоох; мөн шаардлагатай тохиолдолд Банкны зүгээс эдгээр бодлогод үл нийцсэн зөрчлийг арилгах, түүний зэрэгцээ цаашид тийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

ТХХБМ болон түүний чиг үүргийн талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл Төслийн хариуцлагын хараат бус механизмын цахим хуудас, хянан шалгуулах хүсэлт тавих бол Хүсэлт хаягаар тус тус хандана уу. ТХХБМ-ын талаар, мөн санал хүсэлт хэрхэн тавих тухай чиглэл заавар, нэмэлт мэдээлэл авах бол ipam@ebrd.com цахим шуудангаар хандаж болно.